

АЖЛЫН БАЙРНЫ 1

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Дэлхийн банкны санхүүжилттэй, Монгол Улсын засгийн газрын ХХААХҮЯ-ны хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн “Залуу мэргэжилтэн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх нь

Хэрэгжүүлэгч байгууллагын нэр: Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Хүлээн авагч байгууллагын нэр:

Мал аж ахуй эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл

Нэгжийн нэр:

Ажлын байрны нэр:

Экстэншний дадлагажигч ажилтан

Ажлын байрны чиглэл:

шинжлэх ухааны ололтыг хөдөө аж ахуйд нэвтрүүлэх

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, СБД 1-р хороо Парк плэйс оффис, 602 тоот

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл

Хамаарахгүй

II.АЖЛЫН БАЙРНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Ажлын байрны зорилго:

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Төслийн зохицуулагчийн шууд удирдлага дор, шинжлэх ухааны ололтыг хөдөө аж ахуйд нэвтрүүлэх мэргэжилтэн (ES) Мал аж ахуйн мэргэжилтэн, НҮБ-ын

Техникийн туслалцаа багтай хамтарч ажил үйлчилгээгээ уялдуулан, дэмжин ажиллана. Шинжлэх ухааны ололтыг хөдөө аж ахуйд нэвтрүүлэх, цахим мал аж ахуйн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэхэд түншүүд болон техникийн үйлчилгээ үзүүлэгчидтэй уялдуулж дараах ажлуудыг хэрэгжүүлнэ.

Ажлын байрны зорилт:

1. Дэд төслүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
2. ТХН-ийн мэргэжилтнүүдийн ажлын уялдаа холбоог хангаж, төслийн хэрэгжилтийг дэмжих
3. Хамтрагч байгууллагуудтай төслийн ажлын уялдаа холбоог хангах
4. Төслийн тасралтгүй үйл ажиллагаа, тайлагналтад дэмжлэг үзүүлэх

Зорилт	Дадлагажин гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Засгийн газраас хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлого, түүний хэрэгжилттэй төслийн үйл ажиллагааг уялдуулах, • Хөдөө аж ахуйн салбарт баримтлах нэвтрүүлэх бодлого, холбогдох хэрэгжилтийн заавар, суурь судалгаан үр дүнг судалж, нэвтрүүлэх үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөрийн агуулга, хэрэгжилтийн талаарх үндэсний хэмжээнд баримталж буй бодлогыг нарийвчлан ойлгож, малчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн засах шаардлагатай байгаа өөрчлөлтийг тодорхойлж, төслийн байршилд хэрэгжүүлэхдээ цаг уур, үйл ажиллагааны орчин, технологийн өөрчлөлтийн онцлогийг анхаарах;	Дадлагажин эзэмшсэн байна	Т ба Г

	2. НҮБ-ын ХХААБ-ын техникийн туслалцааны багтай хамтран шинжлэх ухааны ололтыг хөдөө аж ахуйд нэвтрүүлэх • НҮБ-ын ХХААБ-ын техникийн туслалцааны баг, хэрэгжүүлэгч түншүүд, малчид, малчдын хоршоо, шинжлэх ухааны ололтыг хөдөө аж ахуйд нэвтрүүлэх үйлчилгээ үзүүлж буй хувийн хэвшил, төрийн байгууллагуудтай зөвлөлдөж, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах; • Шинжлэх ухааны ололтыг хөдөө аж ахуйд нэвтрүүлэх системийн үр ашгийг дээшлүүлэх, цар хүрээг нэмэгдүүлэх замаар малчин өрхийн орлого, малын гаралтай бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх шинэ туршлагыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нэмүү өртгийн сүлжээний ашиг хүртэгчдэд цахим мал аж ахуйн системийг ашиглах боломжийг бүрдүүлэх.	Дадлагажин эзэмшсэн байна	Т ба Г
2 дугаар зорилтын хүрээнд	3. Шинжлэх ухааны ололтыг хөдөө аж ахуйд нэвтрүүлэх системийн үр ашгийг дээшлүүлэх, цар хүрээг нэмэгдүүлэх • Малын эмч, малчид, үржлийн нэгж, орон нутгийн сургалт хариуцсан ажилтанд шаардлагатай ур чадвар, мэдлэг олж авахад шаардлагатай системчилсэн хөтөлбөр боловсруулахад дэмжлэг үзүүлэх сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах • Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн загвар боловсруулах, • Сургагч багшийн гарын авлага боловсруулж, сургалтын хөтөлбөрийн чанарыг хянах загварыг боловсруулах, • Сургалтын үйлчилгээг малчдад үзүүлэхдээ орон нутгийн онцлог, иргэдийн чадавхыг харгалзан үзэж тохируулан өөрчлөх загвар боловсруулах, • Сургагч багшийн боловсруулсан загвар сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавих холбогдох мэдээлэл цуглуулах загвар боловсруулах,	Дадлагажин эзэмшсэн байна	Т ба Г

	- Хамтын оролцоотой хяналт, шинжилгээ, үнэлэх загвар боловсруулах - Сургагч багшийн боловсруулсан сургалтын хөтөлбөрийн дагуу хийсэн сургалтын талаарх хэлэлцүүлгийг ашиг хүртэгч нарын дунд явуулж, сургалтын хөтөлбөрт үнэлгээ өгч, баталгаажуулах		
	4. Төслийн тасралтгүй үйл ажиллагаа, тайлагналтад дэмжлэг үзүүлэх - Цахимаар хүргэх үйлчилгээ, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх сайн туршлага, шинэ ололт амжилтыг баримтжуулж түгээх - Гэрээт ажлын төгсгөлд хэрэгжүүлсэн ажлын тайлан бэлтгэх.	Дадлагажин эзэмшсэн байна	Т ба Г

III.АЖЛЫН БАЙРАНД ТУСГАЙ ТАВИГДАХ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр боловсролын зэрэгтэй, 2.5-аас дээш голч оноотой төгссөн байх,	
Мэргэжил	- Мал аж ахуй (081101); - Эдийн засаг, статистикч (081102); - Статистик 0542 - Өгөгдлийн сан, сүлжээний загварчлал /дизайн/ ба удирдлага 0612 - 0613 Программ хангамж, түүний хэрэглээ хөгжүүлэлт ба шинжилгээ	
Мэргэшил	Мал аж ахуй болон малын тэжээл	
Туршлага	Туршлага хамаарахгүй	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; - хариуцсан ажлын чиглэлээр дүн шинжилгээ хийх, харьцуулсан судалгаа гаргах; - бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийж, үндэслэлтэй санал боловсруулах; - шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- тулгамдаж буй асуудлыг судлах, удирдлагад танилцуулах; - гаргасан шийдвэрийнхээ үр дүнг хариуцах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - бусад.
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг, мэдээллээ хамт олонтой хуваалцах, түгээн дэлгэрүүлэх; - бусадтай хүндэтгэлтэй, адил тэгш, итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - бусдын санал бодлыг анхааралтай сонсож санал санаачилгыг дэмждэг байх; - аливаа асуудлыг хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэдэг байх;

	- аливаа сөргөлдөөн, зөрчилдөөнийг эвээр зохицуулах гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - бусад.	
	Бусад	- олон нийттэй харилцах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэд технологи ашиглах, мэдээллийг шуурхай хүргэх; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх ур чадвартай байх.
IV. ХАРИЛЦАХ СУБЪЕКТ		
<u>Шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</u>		
-		
<u>Бусад харилцах субъект:</u>		
-		
V. АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ		
<u>Ажлын байрны тодорхойлолт боловсруулсан:</u>		<u>Ажлын байрны тодорхойлолтыг танилцаж хүлээн зөвшөөрсөн:</u>
<u>Байгууллагын нэр:</u> Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх		<u>Залуу мэргэжилтний нэр:</u>
<u>Албан тушаал:</u> Төслийн захирал (Гарын үсэг)		(Гарын үсэг) (Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр)
2023 оны дугаар сарын-ны өдөр		2023 оны дугаар сарын-ны өдөр